



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

худал оны 12 сарын 07 өдөр


Дугаар A/532

Улаанбаатар хот

Г Түр заавар шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцосыг оршуулах түр заавар"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Ц.Билэгтсайхан), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Д.Цогбадрах), Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/747 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



141222696

Эрүүл мэндийн сайдын
2022 оны 12 дугаар сарын

07 өдрийн 12 тушаалын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН БАТЛАГДСАН БОЛОН СЭЖИГТЭЙ ЦОГЦОСЫГ ОРШУУЛАХ ТҮР ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү зааврын зорилго нь коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцосыг хүлээж авах, тээвэрлэх, хадгалах, салах ёс гүйцэтгэх, оршуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцост эмгэг судлалын шинжилгээ хийх эсэх тохиолдлыг зохицуулахад оршино.

Хоёр. Цогцосыг хүлээж авах, тээвэрлэх

2.1 Эмнэлэгт нас барсан тохиолдолд авах арга хэмжээ:

2.1.1 Лабораторийн шинжилгээгээр Коронавируст халдварт (КОВИД-19)-ын (бх-ПГУ) батлагдсан эмнэлзүй, тархвар судлалын заалтаар сэжигтэй нас барсан хүний цогцосыг цогцос хадгалах зориулалтын уутанд хийж, халдвартын сэргийлэлт хяналтыг баримтлан тухайн эмнэлгийн байгууллага нь оршуулах үйл ажиллагаа явагдах хүртэл тээвэрлэхгүйгээр хадгална.

2.1.2 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тохиолдол батлагдсан өдрөөс хойш 14 хоног өнгөрсөн буюу халдвартай хугацаа дууссан, халдвартах боломжгүй болсон тохиолдолд ар гэрт нь цогцосыг уутанд хийн хүлээлгэн өгч, ердийн журмаар оршуулна.

2.2 Эмнэлгийн бус нөхцөлд нас барсан тохиолдолд авах арга хэмжээ:

2.2.1 Лабораторийн шинжилгээгээр Коронавируст халдварт (КОВИД-19)-ын (бх-ПГУ) батлагдсан эмнэлзүй, тархвар судлалын заалтаар сэжигтэй эмнэлгийн бус нөхцөлд нас барсан тохиолдолд харьяа цагдаагийн газар, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

2.2.2 Цогцосыг гадны нөлөөтэй нас барагт гэж сэжиглэсэн тохиолдолд Цагдаагийн байгууллагын хяналтан дор эхний очсон эрүүл мэндийн байгууллага цогцосыг цогцос хадгалах зориулалтын уутанд хийж, шүүх шинжилгээний байгууллагад хүргэж өгнө.

2.2.3 Цагдаагийн байгууллага цогцосыг гадны нөлөөгүй нас барагт гэж үзсэн тохиолдолд оршуулгын үйлчилгээ эрхлэх байгууллагад мэдээлнэ. Оршуулгын үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллага нь цогцосыг цогцос хадгалах зориулалтын уутанд хийж, халдвартын сэргийлэлт хяналтыг баримтлан зөөвөрлөх, хадгалах, оршуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

Гурав. Цогцос хадгалах, салах ёс гүйцэтгэх үйл ажиллагааны үеийн халдвартын сэргийлэлт хяналт

3.1 Эмгэг судлалын шинжилгээ хийх, цогцос хадгалах өрөө, салах ёс гүйцэтгэх үйл ажиллагааны үеийн халдвартын сэргийлэлт хяналтыг эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлж, голомтын эцсийн халдвартайгуулэлтийг хийнэ.

3.2 Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эрсдэлээс урьдчилан сэргийлэх журмын дагуу нэг чигийн урсгал хөдөлгөөний маршрутын зураглал заавар гаргасан байна.

3.3 Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг салах ёс гүйцэтгэх өрөө, цогцос хадгалах өрөө, үйлчилгээний танхим, эмгэг судлалын тасаг, нэгжүүдийн албан тасалгаа, цахилгаан шат, ариун цэврийн өрөө зэрэгт байршуулна.

3.4 Коронавируст халдвар (КОВИД-19)-аар нас барсан хүний цогцос хүлээн авсан, хадгалсан, шинжилгээ хийсэн өрөө тасалгааг халдвартай буюу улаан бүс болгож, "Улаан бүсийн тэмдэг" тавина.

3.5 Эмгэг судлалын тасаг, нэгжүүдэд хамгаалах хувцас өмсөх, тайлах хэсэгтэй байна. Хувцас тайлах хэсэгт гарын угаалтуур, гар халдвартай хог хаягдлын шар уут бүхий 50л-ээс дээш хэмжээтэй, хөлөөр онгойдог хогийн сав, эд зүйл болон гутал халдвартай хувцас болон шүүгээ, биеийг бүтэн харах боломжтой толь хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, тайлах дарааллын зураг байрлуулсан байна. Бусад шаардлагатай хэрэгслийн нөөцийг бурдуулсан байна.

3.6 Талийгаачийн нас барах үедээ хэрэглэж байсан хувцас, бусад зөөлөн эдлэлийг шар өнгийн уутанд хийж, аюултай хог хаягдал устгах журмын дагуу устгана. Хэрэв ар гэр авах хүсэлт гаргасан тохиолдолд хувцас болон зөөлөн эдлэлийг угаалгын машинд 60-90°C хэмийн халуун усанд угаах, гараар угаах бол халдвартай хогийн бодис бүхий усанд 30 минут байлгасны дараа угаалгын нунтаг, савангаар угааж, цэвэр усаар сайтар зайлан, нарны гэрэлд хатааж, индуудэхийг зөвлөнө.

Дөрөв. Оршуулах үйл ажиллагаа

4.1 Цогцосыг зориулалтын газарт чандарлах болон булшлах аргаар оршуулах бөгөөд ил тавьж оршуулахыг хориглоно.

4.2 Булшлах аргаар оршуулах тохиолдолд цогцосыг цогцос хадгалах зориулалтын уутнаас гаргахгүйгээр хайрцагт хийнэ.

4.3 Цогцосыг чандарлах үйл ажиллагааг гүйцэтгэж буй байгууллага Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн хууль дүрэм, журмыг чанд мөрдөж ажиллана.

4.4 Салах ёс гүйцэтгэхэд дараах халдвар хамгааллын дэглэмийг баримтлана.

4.4.1 Ар гэрийнхэн цогцост хүрэхгүй, цогцосны уутыг нээхгүй байх

4.4.2 Хүн хооронд 1-1,5 метрээс доошгүй зайд барих

4.4.3 Спиртэн суурьтай гар халдвартай хогийн байршуулах

4.4.4 Ар гэрийн төлөөлөл амны хаалт, нэг удаагийн бээлий өмсөх

4.4.5 Оролцогчдын гарыг халдвартай хогийн байршил

4.4.6 Оршуулах үйл ажиллагаа дуусч, амны хаалт, бээлийг тайлсны дараа гар халдвартай хогийн байршил

4.5 Оршуулгын үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллагууд халдварын сэргийлэлт хяналтыг мөрдөж, дотоод хяналтыг тогтмол тавьж, оршуулах үйл ажиллагаанд тэмдэглэл хөтөлж баримтжуулна.

Тав. Эмгэг судлалын шинжилгээ хийх явцад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй байдал илэрсэн тохиолдолд

5.1 Шалтгаан тодорхойгүй уушигны цочмог өвчнөөр нас барсан, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэл зүйн болон тархвар зүйн холбогдолгүй цогцост эмгэг судлалын шинжилгээг хийхдээ анатомийн эмгэг судлаач эмч, эмнэлгийн мэргэжилтэн, туслах ажилтан нүдний шил, нүүрний хаалт, усны гутал, урт ханцуйтай шингэн ахуйн бээлий өмсөнө.

5.2 Коронавируст халдвар (КОВИД-19)-тай нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан (ICD U.07.1), эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй тохиолдол (ICD U.07.2), уг өвчний хүндрэл нь үхлийн шалтгаан болж нас барсан гэж үзвэл өвчний олон улсын Х ангиллын дагуу оношийг бичиж кодлон эмгэг судлалын шинжилгээг хийхгүй.

5.3 Коронавируст халдвар (КОВИД-19)-тай эхээс төрсөн ураг, нярайг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдол гэж үзэн эмгэг судлалын шинжилгээнд оруулахгүй.

5.4 Хэрвээ эмгэг судлаач эмч шинжилгээ хийх явцад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын сэжигтэй тохиолдлоор нас барсан байх магадлалтай бол мэргэжлийн байгууллагад мэдэгдэж тандалт судалгаа хийлгэх, зааварчилгаа авна.

5.5 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан болон эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй өвчтөн нас барсан үед цогцостой харьцан ажиллах, үзлэг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эрсдэлээс урьдчилан сэргийлж, цар тахлын бэлэн байдалд зохицуулан, хүний нөөцийн зохион байгуулалт хийнэ.

5.6 Эмгэг судлалын задлан шинжилгээний явцад Коронавируст халдвар (КОВИД-19)-аар өвчилсөн байх магадлалтай бол шинжилгээг бага хүрцтэй эмгэг судлалын шинжилгээний аргаар дуусгана.

5.7 Шингэн нэвтрэхгүй материал дэвсэж, цогцосыг уутанд хийн, уутны бүх гадаргууг халдвартайжүүлэн, “Халдварын эрсдэлтэй” гэж тэмдэглэн цогцос хадгалах хэсэгт шилжүүлнэ.

5.8 Хэрэв Коронавируст халдвар (КОВИД-19)-ын онош батлагдсан тохиолдолд цогцост задлан шинжилгээ хийхэд оролцсон алба хаагчдад эрсдэлийн үнэлгээ хийж халдварт өртөх эрсдэлтэй гэж үзвэл өртсөнөөс хойш 5-6 хоног, 13 дахь хоногт Коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх шинжилгээнд хамруулж, энэ хугацаанд эмнэл зүйн шинж тэмдгийн тандалтад хамруулна.

5.9 Цогцост шинжилгээ хийх явцад сэжигтэй тохиолдлоор нас барсан байх магадлалтай бол дээжийг вирус судлалын лабораторид илгээж шинжилгээний хариу сөрөг гарсан тохиолдолд, хими биологийн лаборатори руу шинжлэгдэхүүнийг илгээнэ.

5.10 Шинжилгээ хийсэн гадаргууг угаалгын нунтагтай усаар угаасны дараа 0.1%-ийн содын гипохлоридын уусмал эсвэл 70%-ийн этилийн спиртээр 1-ээс дээш минут халдвартайжүүлнэ.

5.11 Сэжигтэй тохиолдолд өмссөн хамгаалах хувцас, хэрэгслийг зааврын дагуу тайлж, битүүмжлэн, эмнэлгийн халдвартай хог хаягдлыг устгах журмын дагуу хүлээлгэн өгнө.